

## Эрүүл мэндийн салбар

Эрүүл мэндийн салбарын зардал ба эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн хоорондын хамаарал

Хүснэгт 1.

| Улс            | ЭМ-ийн салбарт зарцуулж буй хөрөнгийг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан хувь | НЭМ-ийн чиглэлээр зарцуулж буй хөрөнгө ЭМ-ийн салбарын нийт хөрөнгөнд эзлэх хувь | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | Хүн амын дундаж наслалт |
|----------------|--|--|--|-------------------------|
| АНУ            | 16   | ~40  | 8  | 77.9                    |
| <i>Энэтхэг</i> | 5  | 17   | 95   | 60.8                    |
| Хятад          | 2.7  | 24.9   | 43   | 69.4                    |
| Шриланк        | 3  | 45.4   | 19   | 69.2                    |
| <i>Малайз</i>  | 2.4  | 57.6   | 14   | 68.5                    |
| Өмнөд Солонгос | 6.7  | 37.8   | 14   | 73.2                    |
| <b>Монгол</b>  | <b>4.5</b>   | <b>Нарийн тогтоох боломжгүй (20&gt;байх магадлалтай)</b>                         | <b>22.1</b>                                | <b>66.5</b>             |

Аливаа улс орны эрүүл мэндийн салбарын эрхэм зорилго нь хүн амдаа тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх замаар тэдний амьдралын чанарыг сайжруулж, дундаж наслалтыг уртасган, сайн сайхан аж байдлыг дээшлүүлэхэд оршдог. Манай улсын хувьд ч энэхүү эрхэм зорилгыг хангахын төлөө эрүүл мэндийн салбарын нийт 34000 гаруй эмч, ажиллагсад ажиллаж байна. Эдгээрийн 7079 нь их эмч, 8359 нь сувилагч, 3003 нь бага эмч байгаа нь 10000 хүн амд ногдох эмчийн тоогоор дэлхийн бусад орнуудын дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

2015 оны эхний байдлаар манай улсад тусламж үйлчилгээний 3 шатлалаар нийт 1256 эмнэлэг иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн 587 хувийн хэвшлийн эмнэлэг хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж салбарын нийт ачааллын 10 хувийг үүрэлцэж байна. 2014 оны байдлаар 10000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо 71.1 байгаа нь Номхон далайн баруун эргийн орнуудаас эхний тавд орж байгаа ажээ.

## **Эрүүл мэндийн тухай хууль**

- \* Эрүүл мэндийн тухай хууль 2011 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдан хэрэгжиж эхэлсэн.

Монголын уламжлалт анагаах ухааныг Монголын Брэнд болгох нь өнөөдөр чухал асуудалуудыг нэг болоод байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай эмнэлэг, эмнэлэгийн тусламж үйлчилгээний байгууллага байгуулахад шаардагдах тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагаас авна.

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ “ТӨСӨЛ” БИЧИХ**

1. “Тусгай зөвшөөрөл хүсэгч”-ийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах хэрэгцээ шаардлага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлтэй нийцсэн байна.
2. Төслийг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 39 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 145 дугаар тушаалын дагуу бичиж ирүүлнэ.

### **БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

Гадаадын хөрөнгө оруулалттай болон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эмнэлгийн "тусгай зөвшөөрөл хүсэгч" дараах баримт бичиг бүрдүүлнэ.

1. Тусгай зөвшөөрөл хүссэн албан тоот
2. Үүсгэн байгуулагчийн шийдвэр
3. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
4. Компаний дүрэм
5. Эрүүл мэндийн байгууллагын дүрэм, үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, хүчин чадал, тооцоо;
6. Санхүүгийн тооцоо
7. Эмнэлгийн барилга байгууламжийн схем зураг
8. Эмнэлгийн танилцуулга, эмнэлгийн гадна байдлын зураг
9. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн танилцуулга
10. Байгууллагын дотоод журам
11. Үүсгэн байгуулагчийн мэдээлэл ЭМС-ын 2013 оны 145 тоот тушаалын 1-р, ажиллагсдын судалгааг 2-р, гадаадын эрүүл мэндийн ажилтны мэдээллийг 3-р хүснэгтийн дагуу гаргах

12. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хуулбар, сургууль төгссөн болон мэргэшлийн үнэмлэх, дипломын хуулбар
13. Ажиллагсдын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт
14. Бүтэц, үйл ажиллагааны стандартууд
15. Тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;\_

### **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГУУЛАХ**

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад дараах баримт бичиг бүрдүүлнэ.

1. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахыг хүссэн өргөдөл;
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар хувь;
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувь;
4. Харьяа дүүргийнхээ татварын газраас тодорхойлолт авах; /сүүлийн 3 жилээр/
5. НД-ийн газраас тодорхойлолт авах; /сүүлийн 3 жилээр/
6. Ажиллагсадын мэдээлэл; /Мэргэжлийн эмч, мэргэжилтний дипломын хуулбар/
7. Сүүлийн 3 жилд хийсэн ажлын тайлан;

---

Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээний салбар нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 0.1% хувийг эзэлж байна. Тус салбарт нийт 14,607 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Эрүүл мэндийн салбарт гадны хөрөнгө оруулалттай хувийн хэвшлийн эмнэлэгүүд үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд:

1. УБ Сонгдо эмнэлэг
2. ГрандМед
3. ИнтерМед
4. УлаанбаатарМед эмнэлэг
5. Мөнгөн гүүр эмнэлэг

**Монгол улсын эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй гадны төлөөлөгчийн газрууд :**

- \* Тайландын Бумрунград эмнэлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар
- \* Солонгосын Мёнжи эмнэлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар
- \* Сингапурын эмнэлэгүүдийн Монгол дахь төлөөлөгчийн газар
- \* Солонгосын Анам эмнэлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар

- \* Солонгосын Гүми Гандун Эмнэлгийн Монгол дахь төлөөлөгчийн газар
- \* Энэтхэгийн “Аполло” эмнэлгийн Монгол дахь төлөөлөгчийн газар
- \* Солонгосын Сон эмнэлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар

Монголд эрүүл мэндийн даатгалын өрсөлдөөнт, олон хэлбэрүүд хөгжих хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.

**Эрүүл мэндийн даатгалын тухай хууль**

- \* Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр батлагдан 2015 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн.
-